



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 16/10

Арвайхээр сум

Нийтийн сонсгол зохион байгуулах тухай

Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Аймгийн нутаг дэвсгэрт бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэн орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг тогтоох тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/07 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийх ерөнхий хяналтын сонсголын товыг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Пүрэв гарагийн 09:00 цагт зохион байгуулахаар тогтоосугай.

2. Сонсгол даргалагчаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хорооны гишүүн С.Цогтбаатарыг томилсугай.

3. Нийтийн сонсголын товыг цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх, бусад холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг хариуцан зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (С.Ундрах)-нд даалгасугай.

ДАРГА

Т.НАРАНГАРАВ

622608055